СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр  сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/112/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2023 он | Миндүг Аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал С.Энхтөр<br>Утас: 95957791<br>Цахим хаяг: director@mindug.mn<br>Аудитор    О.Цагаан<br>Утас:  99519341<br>Цахим хаяг: coo@mindug.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.................................... **Error! Bookmark not defined.**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.................................... 5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .................................................................... 11

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .................................................................... 11

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.................................................................... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.................................................................... 11

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.................. 11

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .................................................................. 12

4. АУДИТЫН ТАЙЛАН .................................................................................................... 13

4.1 Ерөнхий зүйл.................................................................................................... 13

4.2 Материаллаг байдал .................................................................................................... 13

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .................................................................. 14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.................... 14

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .................................................................. 14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................................ 15

4.5.1 Завсрын аудитын талаар.................................................................................... 15

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .................................................................................................... 15

5.1 Төлбөрийн акт ....................................................................................................

5.2 Зөвлөмж.................................................................................................... 15

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ............................................15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 89

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Р.ОТГОНСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Сангийн сайдын 2023 оны 10/84 тоот албан тоотоор орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт ирсэн чиглэлийн дагуу гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн нэгтгэхтэй холбоотой дараах залруулга хийгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотойгоор "Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 251,919.0 мянган төгрөг буюу 33.6 хувиар өссөн нь 12,050.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж , тавилга эд хогшил, 39,963.0 мянган төгрөгийн тоглоом ,100.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг хандиваар хүлээн авсан"-аас өөрөөр нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

**Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 7 зорилт 73 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 96.5 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 46,771,948.15 | 82,891,469.81 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 9,276,599.99 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 9,276,599.99 |
| 3121 | Төгрөг | - | 9,276,599.99 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 9,276,599.99 |
| 33 | АВЛАГА | 2,412,385.83 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,412,385.83 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 44,359,562.32 | 73,614,869.82 |
| 351 | Түүхий эд материал | 848,000.00 | 1,393,000.00 |
| 35130 | Эм боох материал | 848,000.00 | 1,393,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 43,511,562.32 | 72,221,869.82 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 539,200.00 | 551,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 41,857,094.82 | 69,394,669.82 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,115,267.50 | - |
| 35460 | Хүнсний материал | - | 2,276,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 149,025,055.10 | 186,575,515.60 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 149,025,055.10 | 186,575,515.60 |
| 392 | Биет хөрөнгө | 142,519,055.10 | 178,829,515.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 137,790,520.91 | 137,790,520.91 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (18,809,375.76) | (25,079,167.68) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21,824,400.00 | 35,202,700.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (11,600,476.25) | (12,287,469.58) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,082,980.00 | 50,408,040.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,449,760.18) | (32,898,541.32) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 37,340,906.00 | 57,175,906.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (29,124,239.62) | (32,946,572.73) |
| 39217 | Ном | 1,464,100.00 | 1,464,100.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 6,506,000.00 | 7,746,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 1,800,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (120,000.00) | (380,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,326,000.00 | 6,326,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 195,797,003.25 | 269,466,985.41 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 1,661,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 1,661,000.00 |
| 413 | Өглөг | - | 1,661,000.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 161,000.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 1,500,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,500,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 195,797,003.25 | 267,805,985.41 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 195,797,003.25 | 267,805,985.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 113,972,900.00 | 113,972,900.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 113,972,900.00 | 113,972,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (72,760,815.68) | (751,833.52) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (64,564,283.17) | -266,145,433.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (8,196,532.51) | 265,393,599.58 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 154,584,918.93 | 154,584,918.93 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 195,797,003.25 | 269,466,985.41 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 498,059,300.00 | 943,363,005.08 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 73,600.00 | 245,397,617.42 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 73,600.00 | 245,397,617.42 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 73,600.00 | 245,397,617.42 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 73,600.00 | 245,397,617.42 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 497,985,700.00 | 697,965,387.66 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 454,929,000.00 | 591,319,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 591,319,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 454,929,000.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 160,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 42,896,700.00 | 106,645,787.66 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 42,896,700.00 | 106,645,787.66 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 506,255,832.51 | 677,661,545.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 506,255,832.51 | 677,661,545.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 497,265,982.47 | 673,285,468.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 357,516,701.37 | 437,013,014.24 |
| 210101 | Үндсэн цалин | 284,631,347.38 | 325,295,189.36 |
| 210102 | Нэмэгдэл | 55,831,942.11 | 93,245,652.05 |
| 210104 | Урамшуулал | 17,053,411.88 | 18,472,172.83 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,463,400.00 | 54,736,744.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,696,500.00 | 37,452,955.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,441,800.00 | 4,348,349.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,753,300.00 | 3,465,319.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,300.00 | 860,530.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,883,500.00 | 8,609,588.12 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,482,298.35 | 32,122,090.64 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,860,133.85 | 4,825,433.14 |
| 210302 | Түлш, халаалт | 16,197,264.50 | 24,657,117.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,424,900.00 | 2,639,540.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,748,800.00 | 5,248,825.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 445,600.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 469,200.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 497,100.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 79,400.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,289,700.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,967,800.00 | 5,248,825.00 |
| 2105 | Нормативт зардал | 38,883,332.00 | 94,289,635.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,278,150.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 36,640,182.00 | 94,289,635.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 965,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,140,000.00 | 16,264,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,140,000.00 | 16,264,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 112,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 112,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 465,342.00 | 1,393,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 465,342.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,393,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,454,108.75 | 32,216,859.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,575,350.00 | 9,302,460.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,963,300.00 | 4,410,720.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,915,458.75 | 18,503,679.50 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,989,850.04 | 4,376,076.86 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,989,850.04 | 4,376,076.86 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,989,850.04 | 4,376,076.86 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (8,196,532.51) | 265,701,459.58 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 307,860.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 307,860.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (307,860.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (8,196,532.51) | 265,393,599.58 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 497,985,700.00 | 697,965,387.66 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 497,985,700.00 | 697,965,387.66 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 454,929,000.00 | 591,319,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 454,929,000.00 | 591,319,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 160,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 42,896,700.00 | 106,645,787.66 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 42,896,700.00 | 106,645,787.66 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 486,311,700.00 | 645,876,787.67 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 486,311,700.00 | 645,876,787.67 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 477,321,849.96 | 641,500,710.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 355,129,460.11 | 434,600,628.41 |
| 210101 | Үндсэн цалин | 282,244,106.12 | 322,882,803.53 |
| 210102 | Нэмэгдэл | 55,831,942.11 | 93,245,652.05 |
| 210104 | Урамшуулал | 17,053,411.88 | 18,472,172.83 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,463,400.00 | 54,736,744.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,696,500.00 | 37,452,955.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,441,800.00 | 4,348,349.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,753,300.00 | 3,465,319.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,300.00 | 860,530.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,883,500.00 | 8,609,588.12 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,037,565.85 | 31,006,823.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,860,133.85 | 4,825,433.14 |
| 210302 | Түлш, халаалт | 16,512,532.00 | 23,541,850.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,664,900.00 | 2,639,540.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,840,000.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 445,600.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 469,200.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 497,100.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 79,400.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,348,700.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 35,385,032.00 | 96,565,635.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,278,150.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 32,179,682.00 | 96,565,635.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,927,200.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,640,000.00 | 5,711,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,640,000.00 | 5,711,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 112,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 112,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 863,342.00 | 1,405,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 863,342.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,405,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,851,050.00 | 17,474,080.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,887,750.00 | 12,854,360.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,963,300.00 | 4,619,720.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,989,850.04 | 4,376,076.86 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,989,850.04 | 4,376,076.86 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,989,850.04 | 4,376,076.86 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 11,674,000.00 | 52,088,599.99 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 42,812,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 42,812,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 42,812,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 42,812,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (42,812,000.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 11,674,000.00 | 9,276,599.99 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 9,276,599.99 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 113,972,900.00 | 154,584,918.93 | -63,026,000.27 | 205,531,818.66 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **113,972,900.00** | **154,584,918.93** | **-63,026,000.27** | 205,531,818.66 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | -1,538,282.90 | -1,538,282.90 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -8,196,532.51 | -8,196,532.51 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **113,972,900.00** | **154,584,918.93** | **-72,760,815.68** | 195,797,003.25 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **113,972,900.00** | **154,584,918.93** | **-72,760,815.68** | 195,797,003.25 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -193,384,617.42 | -193,384,617.42 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **113,972,900.00** | **154,584,918.93** | **-266,145,433.10** | 2,412,385.83 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 265,393,599.58 | 265,393,599.58 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **113,972,900.00** | **154,584,918.93** | **-751,833.52** | 267,805,985.41 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 712,028,900.0 0 | 684,312,710.81 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 712,028,735.00 | 684,312,710.81 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 712,028,735.00 | 684,312,710.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 445,049,700.00 | 434,600,628.41 |
| 210101 | Үндсэн цалин | 373,667,800.00 | 322,882,803.53 |
| 210102 | Нэмэгдэл | 63,040,000.00 | 93,245,652.05 |
| 210104 | Урамшуулал | 8,341,900.00 | 18,472,172.83 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,715,500.00 | 54,736,744.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,985,900.00 | 37,452,955.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,435,400.00 | 4,348,349.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,545,100.00 | 3,465,319.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 886,400.00 | 860,530.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,862,700.00 | 8,609,588.12 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 47,287,500.00 | 31,006,823.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,829,100.00 | 4,825,433.14 |
| 210302 | Түлш, халаалт | 37,958,400.00 | 23,541,850.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | 2,639,540.00 |
| 2105 | Нормативт зардал | 96,565,635.00 | 96,565,635.00 |
| 210502 | Хоол, хүнс | 96,565,635.00 | 96,565,635.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 47,900,000.00 | 47,896,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,900,000.00 | 11,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 36,000,000.00 | 35,996,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,406,000.00 | 1,405,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,406,000.00 | 1,405,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,104,400.00 | 18,101,080.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,854,400.00 | 12,854,360.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,250,000.00 | 5,246,720.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 712,028,900.00 | 693,589,310.80 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 712,028,900.00 | 693,589,310.80 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 712,028,900.00 | 693,589,310.80 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 9,276,599.99 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго нь "Хүүхэд бүрийн ижил тэгш эрхийг хүндэтгэн, хөгжүүлэх сургалт үйл ажиллагааг тоглох явцад нь ойлгомжтой зохион байгуулан эцэг, эхийн итгэлийг дааж уужим сэтгэлтэй ухаалаг монгол хүн төлөвших суурийг тавина." гэсэн зорилгын хүрээнд иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот "Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах"
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай"
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал "Заавар батлах тухай"
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дугаар тушаал "Заавар батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73,669.9 мянган төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 9,276.5 | 9,276.5 |
| Авлага | 2,412.3 | - | -2,412.3 |
| Бараа материал | 44,359.5 | 73,614.8 | 29,255.3 |
| Үндсэн хөрөнгө | 149,519.0 | 186,575.5 | 37,056.5 |
| Нийт хөрөнгө | 195,797.0 | 269,466.9 | 73,669.9 |
| Өр төлбөр | - | 1,661.0 | 1,661.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 195,797.0 | 267,805.9 | 72,008.9 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 195,797.0 | 269,466.9 | 73,669.9 |

- *Мөнгөн хөрөнгө данс: 9.276.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлджээ. Энэ нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7[1]-д заасны дагуу дээд шатны төсөвт төвлөрүүлэхгүйгээр үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.*
- *Нийт орлого 445,303.7 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн, мөн бараа материалын эхний үлдэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 989,460.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 989,460.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 277,431.6 мянган төгрөгөөр бууруулж 712,028.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсөвлөсөн орон тоогоор төсөв батлагдаагүй болон багш нарын хөдөө орон нутагт ажилласаны 5 жилийн тэтгэмж тухайн байгууллагын дансаар олгогддоггүйтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 591,319.6 мянга, орон нутгийн төсвөөс 106,645.7 мянга нийт 697,965.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 684,312.7 мянган төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн 9,276.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвийн үлдэгдэл 4,376.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мян.төг/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|

[1] Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ;

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1** | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 83,287.5 | 67,002.8 | 16,284.7 | 80.5 |
| **2** | 80112-Нийтлэг үйлчилгээ | 25,521.8 | 23,366.9 | 2,154.9 | 91.6 |
| **3** | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 1,900.0 | 1,900.0 | - | 100 |
| **4** | 81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 1,900.0 | 1,900.0 | - | 100 |
| **5** | 81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 96,565.8 | 96,565.6 | 0.1 | 100 |
| **6** | 81816-Зөв Монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 3,774.4 | 3,774.4 | - | 100 |
| **7** | 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 435,140.4 | 429,437.3 | 5,703.1 | 98.7 |
| **8** | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 52,039.0 | 48,465.6 | 3,573.4 | 93.1 |
| **9** | 83201-Ангилагдаагүй бусад | 11,900.0 | 11,900.0 | - | 100 |
| **НИЙТ** | | 712,028.9 | 684,312.7 | 27,716.2 | 96.1 |

Төрийн өмчийн барилгын тогтмол зардлын гүйцэтгэл 80.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь шинээр ашиглалтанд орох цэцэрлэгийн барилгын 4-р улирлын тогтмол зардлыг тайлант онд нэмж баталсан боловч тухайн барилга ашиглалтанд ороогүйтэй холбоотой гэрэл цахилгаан,түлш халаалт, цэвэр бохир усны зардал 16,280.7 , эд хогшил урсгал засварын зардал 4,000.0 , нийт 16,284.7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу иосэн байна .

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор О.Цагаан, гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Бүзмаа, хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК–д 2023 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 506,253.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 7,593.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн түвшинг 75 хувиар буюу 5,695.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[2], 15.2.3[3]-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 1,214.6-8,459.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: гэрэл цахилгааны зардал 1,965.2, цэвэр бохир ус 1,214.6, түлш халаалтын зардал 8,549.8, бараа үйлчилгээний бусад зардал 7,727.1, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 1,447.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Байр ашиглалттай холбоотой зардал өмнөх оноос 60,6* хувиар нэмэгдсэн нь дулаан байлгах үүднээс нэмэлтээр халаагч тенн залгасан болон 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал бага гарч байсан бол тайланд онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.
- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал болон бараа үйлчилгээний бусад зардлууд дотор тээвэр шатахуун, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, хангамжийн бараа материал зэрэг зардлуудыг нийлүүлэх төсвийн төлөвлөлт, зардлын ангилалд өөрчлөлт орсон, мөн бараа материалын үнэ урд оноос 2-3 дахин өссөн нь нөлөөлөл үзүүлсэн байна.
- **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс, хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 7, мэдээллийн хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий урсгал санхүүжилтийн 35 гүйлгээний 626,974.0 мянган төгрөг, зарлагын 4 гүйлгээний 48,568.1 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгсөн

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэг нь нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудалгүй байна.

---

[2] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

[3] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэгт завсрын аудит хийгээгүй.*

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар өгсөн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.*

*Хүснэгт 3* .Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| **Зөвлөмж** | 2 | - | 2 | - | 100 |
| Нийт дүн | **2** | **-** | **2** | | **100** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгсөн.**5.1 Зөвлөмж :**

***5.1.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс, хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 7, мэдээллийн хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий урсгал санхүүжилтийн 35 гүйлгээний 626,974.0 мянган төгрөг, зарлагын 4 гүйлгээний 48,568.1 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан хугацаанд* хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны цахим системд хугацаа хоцроосон 7 мэдээлэл , | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| | | | | | | | | |
| **Дүн** | 1 | 0 | | | | | 1 | 0 |